МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Түвдэнгийн Намсрай	Дугаар	L353
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Эрдэнэдалай сум
Төрсөн газар	Эрдэнэдалай сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Хийдийн даамал		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дамбадаржаалин хийд, Цавчирын хийд	Сүм хийдийн дугаар	ДУЭД 001, ДУЭД 010
Одоогийн сүм хийд	Дамбадаржаалин хийд	Сүм хийдийн дугаар	ДУЭД 002
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-рсарын25	Ярилцлага авсан хүн	Жужа



Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Сангийн далай буюу
Дамбадаржаалин хийд, Цавчирын хийд

Жужа:Түвдэнгийн Намсрай гуайтай энэ хийдийн талаар ярилцана. Та бага байхдаа лам байсан уу?

Намсрай: Би жоохон байхдаа цогчин хийдэд сууж байгаад, лам байж байгаад, тэнд сууж байгаад...

Жужа: Хэдэн насандаа тэнд байсан?

Намсрай: Энэ сүмд үү, за ер нь долоон найман настай , найм есөн настай байхдаа юм уу энэ сүмд сууж ном заалгаж байгаад...Тэгээд шашин ном ч байхгүй болсон, тэгээд хөдөө гарсан.Хөдөө гараад мал малаж явж байгаад тэгээд цэрэгт явсан. Цэрэгт яваад таван жил болоод тэгээд халагдаж ирсэн.Тэгээд данда алба хаасан. Эвлэлийн хүрээн дарга, намын үүрийн дарга, сумын дарга хийж яваад тэгээд тэтгэвэртээ гарсан.Тэгээд тэтгэвэрт гараад энэ хийдэд даа лам хийж байна. Даа лам нэртэй ажил хийж байна. Тэгээд ажил хийгээд арван хэдэн жил болж байна. Арван хоёр гурван жил болж байна, ерөөсөө. Тэгэхэд энэ чинь нэлээн хэдэн ламтай, цогчин хуралтай ийм хийд байсан.

Жужа: Яг энэ хийд одоо хэдэн онд нээгдсэн бэ?

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Намсрай: Энэ хийд үү, 1990 онд юм болов уу даа, за 1991 онд ажилд орсон юм. Арав гаруй ламтайгаар, энэ хийд ажилд ороод анх, тэгээт тэрнээсхойш хурал номдоо цогчин хурдаг байж байгаад тэгээд сүүл рүүгээ нөгөө лам нар нь өтлөөд болиод нас барж бариад тэгээд бараг...

Жужа: Хоёр гурван настай ламын нэр хэн хэн байсан бэ?

Намсрай: Настай лам уу, өө энэ чинь хэн лам гэж байсан ш дээ...өө нөгөө ламынхаа нэрийг мартчихаж.

Жужа: Анхны хамба лам хэн байсан бэ?

Намсрай: Анхны энэ хийдийн хамба лам нь , өө нөгөө ламынхаа нэрийг олохоо байчихаж...

Жужа: Одоо энд настай лам бий юу?

Намсрай: Одоо энд настай лам ерөөсөө ганцхан Намжил гэж лам байгаа. Намжил, Лхамсүрэн гэж хоёр лам байгаа. Наян долоо наймтай, наян тав зургаатай ийм хоёр лам байгаа юм. Одоо энэ хоёр хоёулаа байхгүй байгаа байх. Нэг нь хотод байгаа. Лхамсүрэн нь хөдөө байгаа. Хөдөө мал дээр байгаа. Хөдөө хүүхдүүдтэйгээ байгаа. Энд хурал хурж чадахаа байчихсан юм.

Жужа: Тэр Лхамсүрэн гэдэг лам, Эрдэнэдалай сумд уу?

Намсрай: Лхамсүрэн лам уу, хөдөө юу?

Жужа: Эрдэнэдалай суманд уу?

Намсрай: Хөдөө байгаа.

Жужа: Харин Эрдэнэдалай суманд уу?

Намсрай: Эрдэнэдалай, манай сумынх.

Жужа: Тэр хуучин яг энэ Сангийн хүрээнд сууж байсан уу, яг энд үү?

Намсрай: Үгүй ээ, тэр Лхамсүрэн нь бол Үйлстийн хийд гээд энэ, Цагаан-овоогийн хийд гэж яриад байна ш дээ. Тэнд байж байсан хүн. Аа энэ Намжил нь болвол энэ цогчин сумын Төгрөгийн хийд гэж байна ш дээ, тэнд байсан. Яг энд байсан лам нар нь бол бараг байхгүй болсон.

Жужа: Төгрөгийн хийд нь Дундговь аймагт байсан уу?

Намсрай: Аль?

Жужа: Энэ Намжил гуайн сууж байсан хийд?

Намсрай: Намжилын хийд үү, энэ Төгрөгийн хийд гээд баруун тийшээ. Сайхан –Овоод байгаа, Сайхан –Овоогийн хийд тэнд сууж байсан.

Жужа: Тэгээд энэ таны Цавчирын хийд хэдэн ламтай байсан бэ?

Намсрай: Цавчирын хийд үү, Цавчирын хийд чинь болвол нэг зуу шахам ламтай байсан газар.Арай зуу хүрэхгүй байсан байх, нэг дал наян ламтай байсан байх. Тэгээд энэ чинь одоо 1937, 1938 онд л одоо лам нар нь баригдаад тэгээд хаагдсан юм.

Жужа: Та өөрөө яг хэдэн онд бүртгэлд нь байсан бэ?

Намсрай: би тэнд одоо 1937, гучин найман оны үед л байх даа.Тэгэхэд л байж байсан.

Жужа: Тэнд хэдэн дуган байсан бэ?

Намсрай: За тэнд чинь одоо, дөрөв таван ч дуган байсан юм байна.

Жужа: Ямар ямар дуган байсан бэ?

Намсрай: Энэ чинь одоо цогчин дуган гэж байсан. Ерөнхийдөө дөрвөн дуган байсан юм байна даа.

Жужа: Хэрвээ энд цогчин дуган байвал, нөгөө дөрөв нь хаана хаана байсан бэ? Дэргэд үү, хажууд уу?

Намсрай: Одоо энд цогчин дуган байна, энд хойд талд нь байсан юм. Аа тэгээд энд бас нэг дуган байсан. Энд нэг дуган байсан. Иймэрхүү л дуганууд байсан.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Жужа: Дандаа дөрвөн янзын дугануу байсан уу?
Намсрай: Дандаа ном хурдаг, гол дуган нь бол одоо...Майдрын дуган гээд байсан юм байна.
Жужа: Тэнд майдрын хөшөө байсан уу?
Намрай: Майдар эргэдэг байсан юм. Жилдээ нэг удаа майдар эргэдэг байсан юм. Сор залдаг байсан юм.
Жужа: Майдар хэзээ эргэдэг байсан бэ, ямар улиралд?
Намсрай: Намар, намрын найм есөн сард л эргэж байсан байх.
Жужа: Цам бүжиг гардаг байсан уу?
Намсрай: Цам байсан, цатай байсан.
Жужа: Яг хэзээ гардаг байсан бэ?
Намсрай: Намар л гардаг байсан даа.
Жужа: Майдрын дараа юу?
Намсрай: Тийм, майдар цам хоёр чинь ойролцоо.
Жужа: Энэ цам харайхад хэд орчим лам оролцдог байсан бэ?
Намсрай: Өө тэр чинь ер нь олон шүү дээ.Тэр чинь ерөөсөө нэг арав гаран, за хориод лам оролцож байсан юм гэсэн.
Жужа: Ганжуур эргэдэг байсан уу?
Намсрай: Ганжуурыг чинь одоо майдар эргэхэд л хамт эргэдэг байсан.
Жужа: Хайлан хурдаг байсан уу?
Намсрай: Хайлан хурж гэлэн энэ тэр болдог л байсан?
Жужа: Энэ дугануу юугаар хийсэн байсан бэ?
Намсрай: Дан тоосго, зөнгөөр хийсэн.
Жужа: Энэ дан дугануу уу, эсвэл давхартай юу?
Намсрай: Дан дан.
Жужа: Энэ хэрмэн хашаа байсан уу?
Намсрай: Байсан, том хэрмэн хашаа байсан.
Жужа: Тэгээд энэ лам нар хаана хаана амьдардаг байсан бэ?
Намсрай: Лам нар ер нь тэгээд л ингээд л байшин, хувийн байшинтай, гэртэй. Гэр байшинтай л байсан юм даа, тэгээд л гадуур нь.
Жужа: Дөрвөн талд нь уу?
Намсрай: Аа эргэн тойронд?
Жужа: Суварга байсан уу?
Намсрай: Суварга байсан.
Жужа: Тэр хаана байсан бэ?
Намсрай: Энэ дотор, энэ хэрмэн дотор байсан. Хэд хэдэн суварга байсан шүү.
Жужа: Том хүрд байсан уу?
Намсрай: Байсан, байсан. Энэ дотор нь байсан.
Жужа: Хийдийн тэргүүн хамба лам ямар нэртэй хамба байсан бэ?
Намсрай: Ловон лам нь...
Жужа: Тэргүүн лам нь ловон цолтой байсан уу?
Намсрай: Ловон байсан.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Жужа: Цож лүйжин тавьдаг лам нар байсан уу?
Намсрай: Байхгүй, байгаагүй.
Жужа: Эмэгтэй лам нар?
Намсрай: Байгаагүй.
Жужа: Хийдийн гол шүтээн сахиус ямар сахиус байсан бэ?
Намсрай: Цаньд сахиус байсан.
Жужа: Жасын байшингууд байсан уу?
Намсрай: Байсан.
Жужа: Хэд байсан бэ?
Намсрай: Хоёр ч жас байсан.
Жужа: Ямар ямар жас байсан бэ?
Намсрай: Их жас, баруун жас гээд.
Жужа: Их жас хаана байсан бэ, цогчин сүмийн ойрхон уу?
Намсрай: Аа нэг нь энэ хавьд байсан шиг санаж байна. Нэг нь энд байсан шиг санаж байна.
Жужа: Энд бааюу байсан уу?
Намсрай: Бааюу байсан, бааюу энд байсан.
Жужа: Тэнд Хятад хүмүүс юм зардаг байсан уу?
Намсрай: Хятадууд уу, байгаагүй. Миний мэдэх л байгаагүй ш дээ, дэр үед бол бүү мэд.
Жужа: Энд худаг юм уу, рашаан юм уу, гол байсан уу?
Намсрай: Худаг уу, ус байсан. Ус чинь одоо энэ Дэршийн ус гээд энээд бий.
Жужа: Энд тахилгат овоо байсан уу?
Намсрай: Тахидаг овоо юу, Билэгтийн овоо гэж байсан. Баруун урд нь байгаа. Тахидаг овоо байсан . Одоо тахихаа больчихсон юм даа.
Жужа: Энэ хийдийг хэн хэзээ байгуулсан бэ, энийг та мэдэх үү?
Намсрай: Мэдэхгүй.
Жужа: Тэгээд та хэдэн онд хар болсон бэ?
Намсрай: Би чинь одоо 1937, 1938 онд л хар болсон доо. Тэгээд л хөдөө гараад явчихаж байгаа юм. Мал дээр гараад, мал малласан.Тэр олон жил би шавилж суугаагүй.
Жужа: Тэгээд та энэ өөр сүм хийдэд очсон уу, энэ Эрдэнэдалай сумын?
Намсрай: Үгүй, үгүй.
Жужа: Энэ сумын хамгийн том хийд аль хийд байсан бэ?
Намсрай: Энэ Эрдэнэдалайн чинь одоо Цавчирын л хийд дээ, энэ Сангийн далай хийд. Цагаан-Овоогийн Үнстийн хийд.Одоо энэ рашаантын тэр юуны хийд билээ, энэ гурав л хамгийн гол хийд л дээ.
Жужа: Тэгээд энэ Сангийн далай хийд хэдэн ламтай байсан бэ?
Намсрай: Энэ нэг гурван зуу гаран ламтай байсан гэдэг юм байна лээ.
Жужа: Энэ ямар нэгэн нэр алдартай хутагт хувилгаан лам байсан уу? Таны сууж байсан хийдэд байсан уу, энэ Цавчирын хийдэд?
Намсрай:Байгаагүй ээ, тийм хувилгаан энэ тэр тийм улсууд байгаагүй.
Жужа: Төвдөөс ирсэн лам нар байсан уу?
Намсрай: Байгаагүй.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Жужа: Энэ Цавчирын хийд яг ямар нэртэй байгаа юм бэ, одоо?
Намсрай: Билэгт гэдэг юм, Билэгтийн уул.
Жужа: Тэгээд та хэдэн онд энэ одоогийн хийдийн лам болсон бэ?
Намсрай: Би юу, би энэ хийдэд лам болох юу байхав. Энэ хийдэд би аж ахуй хариуцсан л хүн шүү дээ. Ерөөсөө лам энэ тэр болж хуралд суусан юм байхгүй.
Жужа: Тэгээд одоо энэ хийд хэдэн ламтай вэ?
Намсрай: Одоо бол нэг долоон найман хүн байгаа юм л даа.
Жужа:Хийдийн гол шүтээн сахиус ямар сахиус вэ?
Намсрай: Энд Лхам сахиустай.
Жужа: Өдөр болгон хурал хурдаг уу, үгүй юу?
Намсрай: Үгүй, дүйчэн өдрүүдэд л хурдаг юм. Одоо хурах лам байхгүй, ерөөсөө. Одоо лам нар гэвэл ерөөсөө энэ хоёр гуравхан лам байгаа юм. Хурал ном үзэхээ байчихсан, лам нар нь байхгүй болчихсон юм, ерөөсөө.
Жужа: Энэ шинийн найман, дүйчэн өдрүүдэд ямар ямар хурал хурдаг вэ?
Намсрай: Шинийн найманд бол одоо, арван таванд бол гүнрэг хурна. Хорин есөнд одоо арван хангал хурна.
Жужа: Шинийн найманд ямар хурал хурдаг вэ?
Намсрай: Шинийн найманд агдин чог хурдаг юм.
Жужа: Одоогийн хамба хэн бэ?
Намсрай: Батбилэг гэж хамба байдаг юм даа, дэд хамба.
Жужа: Тэр хэдэн настай вэ?
Намсрай: Одоо чинь Батбилэг чинь гучин найм, есөн настай юм уу даа.
Жужа: Энд майдар эргэдэг үү?
Намсрай: Майдар эргэдэг юм.
Жужа: Хэзээ эргэдэг вэ?
Намсрай: Энэ найман сард л эргэдэг юм даа.
Жужа: Энд хоёр суварга байна, тийм ээ гадаа?
Намсрай: Хоёр суварга бий.
Жужа: Тэр хуучин суваргууд уу, шинэ үү?
Намсрай: Өө энэ шинэ шинэ барьсан суварга.
Жужа: Хэдэн онд баригдсан юм бэ?
Намсрай: Энэ чинь одоо ерэн зургаан онд байх аа. Хоёулаа зэрэг баригдсан юм.
Жужа: Энэ ламд зориулж босгосон суварга уу?
Намсрай: Хүнд зориулсан юм байхгүй. Зүгээр л энэ хоёр суварга бүтээсэн юм.
Жужа: Энэ одоо яг хуучин цогчин дуган, тийм ээ?
Намсрай: Энэ цогчин дуган.
Жужа: Өөр энэ хуучин байшин байгаа юу, одоо Сангийн далай хийдийн?
Намсрай: Энд үү, энэнээс өөр юм байхгүй болсон. Энэ дуганаас өөр юм байхгүй.
Жужа: Хуучнаар энэ хийд хэдэн ламтай байсан бэ?
Намсрай: Гурван зуу гаран ламтай байсан юм шиг байна лээ.
Жужа: Тэгээд хэдэн дугантай?

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Намсрай: Өө энэ чинь олон дуган байсан байх шүү.
Жужа: Цавчирын хийдэд ямар нэгэн дамжаа барьдаг байсан уу?
Намсрай: Байгаагүй.
Жужа: Энэ дацан байсан уу, тэнд мамба дацан гэх мэт?
Намсрай: Тийм юм байгаагүй.
Жужа: Ламиран?
Намсрай: Байхгүй ээ.
Жужа: Сахиусны дуган гэж байсан уу?
Намсрай: Сахиусны дуган гэж байсан л байх даа. Мэдэхгүй байна.
Жужа: Тэнд ганжуур данжуур байсан уу?
Намсрай: Байсан л байх даа, мэдэхгүй байна.
Жужа: Тэгээд танай хийдэд байсан өндөр настай лам?
Намсрай: Байхгүй ээ.
Жужа: Тэнд ямар нэгэн туурь байгаа юу?
Намсрай: Туурь бол байгаа.
Жужа: Энийг дахин сэргээсэн үү?
Намсрай: Үгүй.
Жужа: Энэ хийдийн ганц нэг байшин байхгүй юу?
Намсрай: Юу ч байхгүй, галд шатаачихсан.
Жужа: За баярлалаа.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон